



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.05 № 01/727  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-  
ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ЦЭРЭНДОРЖИЙН НАРАНГЭРЭЛ  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Цэрэндоржийн Нарангэрэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

### Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

### Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

## Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Цэрэндоржийн Нарангэрэлийн Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох бусад хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Цэрэндоржийн Нарангэрэлийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (1 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Цэрэндоржийн Нарангэрэлд

Хувийг: Хөвсгөл аймгийн Чандмань-Өндөр сумын Сонгуулийн хороонд

Хавсралт ./. хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ИТХ-ЫН СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ЦЭРЭНДОРЖ ОВОГТОЙ НАРАНГЭРЭЛ  
МИНИЙ СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**Хөтөлбөрийн зорилго**

Орон нутгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхийн төлөө иргэдээ төлөөлөн идэвх санаачилгатай ажиллана.

**Хөтөлбөрийн үндсэн заалт**

**1. Эрүүл мэндийг чиглэлээр:**

1. Өвчлөл нас баралтын тэргүүлэх шалтгаан болсон Халдварт бус өвчин /зүрх судас, харвалт, хавдар, чихрийн шижин, осол гэмтэл г.м/-ийг эрт илрүүлж түүнээс урьдчилан сэргийлэх эмчлэн, эрүүлжүүлэх ажлыг орон нутагт үр дүнтэй зохион байгуулах, өвчлөлийг бууруулахад идэвх санаачилгатай ажиллах
2. Эх хүүхдийг эрсдэлээс хамгаалах, 0-5 настай хүүхдийн тусламж үйлчилгээг сайжруулахад чиглэсэн төлөвлөгөөт ажлуудыг хийж хэрэгжүүлэх
3. Өрх, гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих хөдөлгөөн өрнүүлж, эрүүл мэндээ дээдлэгч иргэн, гэр бүл, хамт олныг шалгаруулан олон нийтэд сурталчлах нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
4. Өрх гэр бүлийг хашаандаа сайхан амьдрах боломжийг бүрдүүлж, стандартад нийцсэн ариун цэврийн байгууламжийг тоог нэмэгдүүлэх, "Эрүүл Чандмань" хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд санаачилгатай хамтран ажиллана.
5. Архины хэрэглээг бууруулах чиглэлээр үр дүнтэй ажлыг зохион байгуулна.
6. Иргэдийг соён гэгээрүүлэх, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургагч багш, лекторуудыг урьж сургалт, уулзалт зохион байгуулна.

**2. Бусад чиглэлээр:**

1. Эмэгтэйчүүдийн эрх ашгийг дэмжиж нийгэмд оролцох оролцоог сайжруулж тэдэнд чиглэсэн ажлуудыг үе шаттай зохион байгуулна.
2. Ээжүүдээ алдаршуулах, үр хойч доо өв соёлоо өвлүүлэн үлдээх ажлыг зохион байгуулна.
3. Залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай зэргийг шийдвэрлүүлэхэд сумын бодлогын баримт бичигт тусгуулах
4. Сумын дэд бүтцийг сайжруулах ажлуудыг хийж хэрэгжүүлэхэд шийдвэр гаргах түвшинд нөлөөлж ажиллана./зам, гэрэлтүүлэг, эрчим хүч г.м/
5. Жижиг дунд үйлдвэр үйлчилгээ, худалдаа эрхлэгчдийг дэмжих, төсөл хөтөлбөрт хамруулах /малын гаралтай түүхийг боловсруулах, ахуйн үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих/
6. Өрхийн түвшинд хүнсний ногоо, хүлэмж, жимс жимсгэнийн тариалалтыг нэмэгдүүлэх нэр төрлийг олшруулах, зөв зохистой хооллолтыг дэмжсэн ажлуудыг зохион байгуулах
7. Малчин өрхийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулах хашаа хадлагийн талбайг хамгаалах ажлыг дэмжих, булаг шанд, рашаан усыг хамгаалах эрүүл мэндийн ач холбогдлыг судлах ажлыг зохион байгуулна.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН Ц.НАРАНГЭРЭЛ



1720000001 1720000005  
00000001